

# МОНГОЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМГААЛАЛТЫН НЭГДСЭН ХОЛБООНД

## ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг шаардлага

1.1. МАБХНХ-ны дүрмийн 5.1.1-т заасны дагуу Монгол улсад аюулгүй байдал, хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, хувь хүн гишүүнээр элсэж болно.

1.2. Холбооны үйл ажиллагаа, дүрэм, журмыг хүлээн зөвшөөрч, гишүүнээр элсэх тухай албан хүсэлтээ “Гишүүнчлэл хамтын ажиллагааны хороо”-нд ирүүлж бүртгэлийн гэрчилгээ авна.

### Хоёр. Гишүүний эрх, үүрэг

2.1. Гишүүн нь дараах эрхийг эдэлнэ.

2.1.1. Гишүүн нь хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах, холбооноос дэмжлэг авах эрхтэй.

2.1.2. Холбооны үйл ажиллагааны хүрээний асуудал, Холбооны бодлого шийдвэрт санал, байр сууриа илэрхийлэх, санал санаачилга гаргах, санал шүүмжлэл тавих эрхтэй.

2.1.3. Холбооны их хуралд оролцож Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвших, сонгох, сонгогдох эрхтэй.

2.1.4. Гишүүний татвараа төлснөөр холбооноос үзүүлэх үйлчилгээнүүдэд хамрагдах.

2.1.5. Холбооноос зохион байгуулж буй гадаад болон дотоод арга хэмжээнүүдэд оролцох.

2.1.6. Холбооны талаарх болон холбооны үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллээр хангагдах.

2.1.7. Холбооны шагналаар өөрийн ажилтан албан хаагчдаа нэр дэвшүүлэн шагнуулах эрхтэй.

2.1.8. Холбооны гишүүн нь холбооны сургалтад хөнгөлөлтэй үнээр ажилтнуудаа хамруулах эрхтэй.

2.1.9. Холбооны гишүүн нь холбооны мэдээллийн санг үнэ төлбөргүй ашиглах эрхтэй.

2.1.10. Холбооны гишүүн нь холбооны цахим хуудсаар байгууллагаа сурталчлуулах эрхтэй.

2.1.11. Холбооны гишүүн нь шинэ мэдээлэл, арга технологитой танилцах эрхтэй.

2.1.12. Холбооны гишүүн нь холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлантай танилцах эрхтэй.

2.2. Гишүүн нь дараах үүргийг хүлээнэ.

2.2.1. Холбооноос зохион байгуулах аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.

2.2.2. Холбооны үйл ажиллагааны санхүүгийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор жил тутам гишүүний татвар төлнө.

2.2.3. Холбооны гишүүний татварт нэг сарын гучин мянган төгрөг, нэг жилийн гурван зуун жаран мянган төгрөг төлнө.

2.2.4. Холбооны гишүүнд шинээр элсэгч нь тухайн жилийн аль сард элсэж байгаагаас хамааран үлдсэн сарын татварыг бүтэн төлнө.

#### Гурав. Гишүүнээр элсэх

3.1. Холбоонд гишүүнээр элсэгч нь дараах материалыг бүрдүүлж өгсөнөөр гишүүний эрх нээгдэнэ.

3.1.1. Гишүүнээр элсэхийг хүссэн албан хүсэлт

3.1.2. Гишүүний анкет

3.1.3. Гишүүнээр элсэх байгууллагын товч танилцуулга

3.1.4. Гишүүний татвар төлсөн баримт. / МАБХНХолбооны Хаан Банк 5040511353 тоот данс, Худалдаа Хөгжлийн банкны 415097487 тоот данс /